

## ХЯТАД УЛСЫН НООЛУУРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН ОРЧИН, ТҮҮНИЙ НӨЛӨӨЛӨЛ

Б.БАТЖАРГАЛ\*

Одоогоос 150 гаруй жилийн өмнөөс Хятад улс ноолууран эдлэл үйлдвэрлэн Европын орнуудад тогтмол экспортлож байжээ. Гэсэн хэдий ч Хятад улсад ноолуурын үйлдвэрлэл 1970-аад оноос хөгжиж эхэлсэн гэж үздэг. Дэлхийн ноолуурын жилийн үйлдвэрлэл сүүлийн 10 гаруй жилийн турш 18000 тонн орчим хэмжээнд тогтвортой байна. Үүний 70 хувь буюу 13000 орчим тонныг Хятад улс, 3000 гаруй тонныг Монгол улс, 2000 гаруй тонныг ОХУ, Иран болон Төв, Баруун Азийн орнууд тус тус үйлдвэрлэдэг байна<sup>1</sup>.

д/д	Он	Бэлтгэсэн Ноолуур (тонн)	Ямааны тоо
1	1990	5751	40 сая
2	2000	11057	53 сая
3	2003	13528	69 сая

Хятадын хөдөө аж ахуйн эрдэм шинжилгээний байгууллагуудаас олон жилийн турш хэрэгжүүлсэн зохиомол селекцийн төслийн үр дүнд хятадын ноолуурын чанар эрс сайжирсан байна. Ялангуяа Өвөрмонголын ямааны ноолуур нь маш зөөлөн, цав цагаан өнгөтэй бөгөөд урт нь 36 орчим мм, голч нь 15.3 микрон байна.


Хятад улс дотоодоос бэлтгэсэн ноолуураа боловсруулахын зэрэгцээ жилд 3000 гаруй тонн ноолуурыг Монгол улс болон Турк, Иран, Казахстан зэрэг орноос импортоор авдаг байна. Одоогийн байдлаар Хятад улсад нийт 2600 гаруй ноолуурын үйлдвэр үйл

ажиллагаа явуулж байгаа бөгөөд эдгээр үйлдвэрүүд дэлхийн түүхий ноолуурын 93 орчим хувийг хэрэглэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Хятад улсад ноолуурыг дахин боловсруулах үйлдвэр 1000 гаруй байдаг бөгөөд эдгээр үйлдвэрүүд жилд 40 гаруй сая ширхэг ноолууран эдлэл үйлдвэрлэдэг байна. Хятад улсын ноолуурын үйлдвэрлэл дэлхийн ноолуурын түүхий эдийн нөөцийн дийлэнх хувийг дотооддоо боловсруулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж бүрдсэн нь уг зах зээлийн үнэмлэхүй давуу тал болж байна.

Дэлхийн хэмжээнд ноолуур экспортлогч хамгийн том улс болох Хятад улсын ноолууран эдлэлийн голлох зах зээл нь Европын орнууд, АНУ, Япон, Сянган бөгөөд эдгээр улсуудад 2000 онд нийт 7 сая ширхэг ноолууран цамц экспортлож байсан бол энэ тоо 2004 онд 14 сая-д хүрч өссөн байна.

Хятад улсын ноолуурын импортын динамик 1994-2004 онуудад



\*Б.Батжаргал.Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-ны ажилтан.

<sup>1</sup> "Influence of Agricultural Industrial Policy on Cashmere Industry" by Jia Youling, China National CVO and Director General of Veterinary Bureau of the Ministry of Agriculture of PRC, April 12, 2005

Хятад улс 2004 онд нийт 1.2 тэрбум ам.долларын ноолууран бүтээгдэхүүн экспортлосон нь өмнөх онтой харьцуулхад 41.2 хувиар өссөн байна. Хятад улс 2004 онд нарийн ноолуур 4136 тонн, ээрмэл ноолууран утас 3806 тонн, ноолууран цамц 14.37 сая ширхэг, ноолууран ороолт 249 сая ширхэгийг экспортлосон байна.<sup>2</sup>

Ноолуурын салбарын үйлдвэрлэлийн өндөр технологи болон шилмэл загварууд Европын орнууд (Итали, Англи), АНУ зэрэг хөгжингүй орнуудын хяналтад байдаг бөгөөд энэ чиглэлээр Хятад улс нэлээд хоцорч хөгжиж байгааг хятадын дотоодын томоохон ноолуурын үйлдвэрлэгчид хүлээн зөвшөөрдөг байна.

Өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд Хятадын төр, засгаас ноолуурын үйлдвэрлэлийг хөгжүүлэхдээ бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний төрлийг олон болгох, технологи солилцоог эрчимжүүлэх, хэрэглээг урамшуулах, хэрэглэгчид үнэн зөв ойлголт өгөх зэрэгт голчлон анхаарч иржээ. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлснээр үр ашиггүй барилга ихээр баригдаж, үнийн хэт өрсөлдөөн, хуурамч бүтээгдэхүүн үйлдвэрлэл бий болж, загвар муутай бүтээгдэхүүн олноор үйлдвэрлэгдэх болсон байна.

Ноолуурын бизнес ашиг ихтэй байдаг тул хятадын ноос боловсруулах үйлдвэрүүд бие биенээсээ уралдан үйлдвэрлэлээ өөрчилж ноолуур боловсруулах болж, мөн дотоодын ноолуурын үйлдвэрүүд үйлдвэрлэлийн хүчин чадлаа өргөжүүлэхийн зэрэгцээ гадаадын ноолуур боловсруулах үйлдвэрүүд олноор байгуулагдснаар одоогийн энэхүү “хэт их” үйлдвэрлэлийн хүчин чадал бий болсон ажээ. Ийнхүү үйлдвэрлэлийн хүчин чадлын илүүдэл бий болсноор хятадын ноолуурын үйлдвэрүүдийн түүхий эдийн үнийг ихээр нэмэгдүүлж, дотоод зах зээлд гажуудал үүсгэж байгаа ажээ.

“Бидний олон жилийн туршлагаас үзэхэд зах зээл дээр ноолуурын нийлүүлэлт сайн байх үед түүхий ноолуур болон эцсийн бүтээгдэхүүний үнэ улам бүр багасаж, харин чанар нь тэр хэмжээгээр улам сайжирдаг

байхад ноолуурын олдоц багасах тусам түүхий ноолуур болон эцсийн бүтээгдэхүүний үнэ нэмэгдэж, улмаар чанар нь мууддаг” хэмээн Өвөр Монголын “Ордос” үйлдвэрийн Ерөнхийлөгч Ван Линсян 2005 оны 4 дүгээр сарын 12-13-ны өдрүүдэд БНХАУ-ын нийслэл Бээжин хотноо зохиогдсон “Хятадын Олон улсын Ноолуурын Чуулга уулзалт” дээр тавьсан илтгэлдээ дурдсан байна.

Зах зээл дээр өөрийн гэсэн байр сууриа олоогүй жижиг үйлдвэрүүд, жижиг наймаачид түүхий ноолуур дээр төрөл бүрийн хольц холих, улмаар хуурамч бүтээгдэхүүн үйлдвэрлэх болсон нь хятадын ноолуур үйлдвэрлэгчдийн хэвийн үйлдвэрлэл болон тэдний гадаад зах зээлийн нэр хүндэд маш сөргөөр нөлөөлж байна. Ийнхүү хууран мэхлэх арга нь олон төрөл хэлбэртэй байдаг. Жишээ нь ноолуур дээр өнгийг нь ангижруулсан тэмээний ноос холих, богино ноолуурыг урт ноолууртай холих, ямааны сайтар угаасан ноосыг ноолууртай холих зэрэг аргаар хуурамч бөгөөд үнэ хямдтай бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг байна. Ялангуяа сүүлийн жилүүдэд угаасан хонины ноосыг ноолуур хэмээн хуурамчаар нэрлэн олон нийтэд зарлах явдал Хятадад ихээхэн гарах болжээ.

Хятадын ноолуурын үйлдвэрлэл ямагт хямд үнийг баримжаалж борлуулалтаа нэмэгдүүлэх бодлого баримталж ирсэн нь урт хугацааны туршид бүтээгдэхүүний чанар болон загварт сөргөөр нөлөөлөх болсон.

**Хятадын ноолуурын зах зээл төлөвшиж, улмаар ноолуурын үнэ тогтворжиж байна**

Байгаль орчныг хамгаалах чиглэлээр 1998 оноос эхлэн Хятадын Төрийн Зөвлөл тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлж эхэлсэн болон ноолуурын үнийн бууралт зэрэг нь хятадын ноолуурын үйлдвэрлэлийн хэмжээнд ихээхэн нөлөө үзүүлсэн. Гэсэн хэдий ч жилийн ноолуурын үйлдвэрлэлийн хэмжээ ойролцоогоор 12000 тонн байгаа бөгөөд цаашид ч энэ түвшин хадгалагдах төлөвтэй байна.

Нийлүүлэлт ийнхүү тогтвортой байх төлөвтэй байхад зах зээлийн эрэлт нэмэгдэж

<sup>2</sup> “The Status quo and Development Trend of the Cashmere Industry in China” by Wang Linxiang, President of “Erdos Cashmere” Company Inner Mongolia, April 12, 2005

байгааг хятадын ноолууран бүтээгдэхүүний дотоод хэрэглээ 5 жилийн дотор 2 дахин нэмэгдэж 2004 онд 10 сая ширхэг ноолууран бүтээгдэхүүн дотооддоо борлуулсан байгаагаас харж болно.

Нэг талаас хэрэглээ ийнхүү хурдацтай нэмэгдэж, нөгөө талаас нийлүүлэлт тогтвортой хэмжээнд байгаа нь ноолуурын үнийг нэмэгдүүлэхэд хүргэж байна. Энэ хандлага ойрын ирээдүйд ч хадгалагдах төлөвтэй байна.

Хятадын ноолуурын зах зээлийн хувьд 1988, 1994 болон 2000 онуудад болсон түүхий ноолуурын өрсөлдөөнөөс болж ноолуурын үнэ огцом нэмэгдсэн нь хятадын олон үйлдвэрлэгч нарт томоохон сургамж болсон. Энэ сургамж дээр үндэслэн хятадын ноолуурын томоохон үйлдвэрлэгч нар богино хугацааны үнэ хөөрөгдөлтөд өртөхөөс сэргийлж түүхий эд худалдан авалтаа үнэ бодит хэмжээндээ хүртэл хүлээдэг болжээ.

1999 оны эхэнд Хятадад ноолуурын үнэ маш их буурсан үед Хятад улсын Засгийн газар тусгай сангаас 300 сая юаний хөрөнгө зарцуулж 1200 тонн ноолуур худалдан авч, нөөц бий болгох замаар зах зээлийн тогтвортой байдлыг хангах макро түвшний арга хэмжээ авч хэрэгжүүлж иржээ.

Сүүлийн 2 жилийн туршид түүхий эдийн худалдан авалт, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хоорондох хугацааг уртасгаж ноолуурын цаг зуурын үнийн хэлбэлзлийг саармагжуулж чадсаны үр дүнд хятадын ноолуур үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хэвийн явагдах боломжтой болжээ.

**Ноолуурын үйлдвэрлэлийн өндөр технологи Хятад руу шилжиж байна**

Хятадын Төрийн Зөвлөлөөс ноолуурын чиглэлээр баримталж буй бодлогын хүрээнд хятадын ноолуур боловсруулах

үйлдвэрүүдийг түүхий эдийн нөөцийн эх үүсвэр, газар нутгийн тохиромжтой байрлал, ажиллах хүчний нөөц боломж зэрэг таатай нөхцлүүдэд түшиглүүлэн Өвөрмонголын ӨЗО-ы Ордос, Бугат, Линхэ, Хэбэй мужийн Цинхэ, Лисэнь болон Нинься мужийн Линву, Тунсинь зэрэг газруудад төвлөрүүлэн хөгжүүлж байгаа бөгөөд эдгээр нь хятадын ноолуур боловсруулах хүчин чадлын 80 хувийг эзэлдэг байна. АНУ, Япон болон Европын зарим ноолуур үйлдвэрлэгчид аажмаар үйлдвэрээ Хятадад байршуулж буйтай холбоотойгоор ихээхэн хэмжээний санхүүгийн хөрөнгө, технологи, шилмэл загвар болон барууны худалдаа, үйлчилгээний хэлбэрүүд дээр дурдсан газруудад нэвтэрч эхэлж байна.

Хятадын ноолуур үйлдвэрлэгчдийн хувьд өөрийн гэсэн загвараар дэлхийн тавцанд гарах нь тэдний тэргүүн зэргийн зорилт болж байна. Хэдийгээр гадаадын ноолуурын томоохон компаниуд хятадад хөрөнгө оруулж байгаа ч загварын чиг хандлагыг Англи, Италийн хэдхэн компаниуд тодорхойлсон хэвээр байна.

Оёмол, нэхмэл бүтээгдэхүүний квот байхгүй болсноор хятадын ноолууран бүтээгдэхүүн дэлхийн зах зээлд чөлөөтэй гарах боломжийг олгож байна. Хятадын Төрийн Зөвлөлөөс самнасан ноолуурын экспортод олгодог байсан экспортын татварын буцаан олголтыг цуцалсан нь хятадаас самнасан ноолуур импортлож, түүгээрээ бүтээгдэхүүн хийж борлуулдаг байсан

Хятад улсын хагас боловсруулсан ноолуурын экспорт (1994 - 2004 онуудад)



барууны олон компаниудад сөргөөр нөлөөлж улмаар тэдгээр компаниуд үйлдвэрээ Хятад руу шилжүүлж байна.

**Хятадын Төрийн Зөвлөлөөс 2004 онд экспортын барааны нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтод томоохон өөрчлөлт оруулж зарим аж үйлдвэрийн бараа, уул уурхайн баяжуулсан бүтээгдэхүүн болон ноолуурын экспортын татварын буцаан олголтыг цуцалсан.** Төрөл бүрийн оёмол, нэхмэл бүтээгдэхүүний экспортын татварын буцаан олголтыг 17 хувиас 13 хувь болгон бууруулсан.

Сүүлийн 2 жилийн дүнгээс үзэхэд Хятадын хагас боловсруулсан ноолуурын экспорт буурсаар байна. Хятадын хагас боловсруулсан ноолуурын экспорт 2003 онд 4540 тонн байсан бол 2004 онд 4136 тонн болж буурчээ. Үүний зэрэгцээ Монгол улс болон Баруун Азийн орнуудаас авдаг ноолуурын импортын хэмжээ хурдтай өсчээ. Жишээлбэл тус улсуудаас 2002 онд 606 тонн ноолуур импортлож байсан бол 2004 онд 2482 тонн болж, жил тутам дунджаар 154 хувиар өссөн байна.

Хятадын Засгийн газраас бүрэн боловсруулсан ноолууран бүтээгдэхүүний экспортыг бодлогоор дэмжиж буй учраас хагас боловсруулсан ноолуурын экспорт буурч, ноолуурын импортын хэмжээ нэмэгдэж байна.

Итали, Англи болон Япон зэрэг улсууд дахь ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрүүд голчлон Хятадаас жил бүр хагас боловсруулсан ноолуур импортлон авдаг бөгөөд 2003 онд дээрх орнууд нийт хэрэгцээнийхээ 91 хувийг Хятадаас импортлосон байна. Хятадын ноолуур нь дэлхийн дээд зэргийн ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нарын түүхий эдийг хангагч гол эх үүсвэр болж чадсан байна.

**Экологи – Ямааны тоо хэмжээ – Ноолуурын гарцын тэнцвэрийг хадгалах**

Хятад улсын мужууд дотор бэлчээрийн мал аж ахуйд тохиромжтой 12 муж байдаг бөгөөд эдгээр мужуудад голчлон ноолуурын ямаа үржүүлдэг байна. Хятад улсын нэг

ямаанаас гарах ноолуурын дундаж гарц 183 грамм байдаг бол бэлчээрийн 12 мужид ноолуурын гарц 235 грамм байдаг байна.

Сүүлийн жилүүдэд ноолуурын үнэ өссөнтэй холбоотойгоор ямааны тоо асар хурдацтай нэмэгдэж, улмаар бэлчээрийн даац хэтэрч, хөрсний дахин сэргэх чадварыг алдагдуулж, цөлжилт явагдахад хүргэж байна. Хятадын хойд хэсэгт бэлчээрийн даац 36.1 хувьтай байна гэсэн тооцоо гарчээ. Хятадын эрдэмтдийн судалгаагаар Хятадын хойд хэсэг дэх одоогийн өвсний гарц 1960 оны үетэй харьцуулахад 35-65 хувиар багассан байна.

Хятадын Төрийн Зөвлөлөөс Баруун бүсийг хөгжүүлэх стратегийг хэрэгжүүлж эхэлсний 5 жилийн ойгоор Хятадын Төрийн Зөвлөлийн Ерөнхий Сайд Вэнь Зябао цаашид хэрэгжүүлэх 6 зорилт дэвшүүлсний эхнийх нь хөдөө аж ахуй, малчидтай холбоотой асуудлуудыг шийдвэрлэхээр заажээ.

Хятад улс одоо гаргаж буй нийт ноолуурын хэмжээгээ хэвээр хадгална гэж тооцоод нэг ямаанаас гарах ноолуурын гарцыг 100 граммаар нэмэгдүүлбэл одоо байгаа ямаан сүргээ 14 сая толгойгоор буюу 29.2 хувиар хорогдуулах боломжтой гэсэн тооцоог хятадын эрдэмтэд хийжээ.

Хятад улс ямааны үүлдэр угсааг шинжлэх ухааны үндэстэй сайжруулах замаар ноолуурын гарц муутай үүлдрийг хасч, сайн чанарын ноолуурын гарц сайтай Өвөрмонголын цагаан ямаа, Ляонинь мужийн ямаа зэрэг сайн үүлдрийн ямаагаар сүргийг сэлбэх ажлыг урт хугацаанд хэрэгжүүлэх зорилт тавьжээ. Хэрэв одоогийн байгаа бүх ямаан сүргийг зөвхөн Өвөрмонголын цагаан ямаа, Ляонинь мужийн ямаагаар бүрдүүлбэл Хятад улс одоогийн авч буй ноолуураас 2-3 дахин илүү хэмжээний их ноолуур авч болохоор байна<sup>3</sup>.

Ямааны тоо ихэссэнтэй холбоотойгоор бэлчээр муудаж, дахин сэргэлт нь удааширч байгаа тул ямааг бэлтгэсэн тэжээлээр хооллох аргыг өргөнөөр нэвтрүүлэх ажлыг эхлүүлж байна.

Хятадын “Викшн групп” компани ямааг бэлчээрлүүлэх бус тэжээлээр хооллох замаар ноолуурын гарцыг нэмэгдүүлж,

<sup>3</sup> “Pasture Eco-environment and Sustainable Development of Cashmere Goat Industry” by Professor Eco-Environment Institute, Inner Mongolia University of Agriculture. 2005.

чанарыг сайжруулах чиглэлээр томоохон судалгаа, туршилтын ажил явуулж байна. Энэ судалгааны ажлын үр дүнд ямааны тэжээлд байвал зохих тэжээллэг бодисуудын хэмжээг тодорхойлж, улмаар ямаан дахь протейныг амин хүчлийн түвшинд хүргэх судалгааны дүнд амин хүчлийн тэнцвэрийн индексийг тодорхойлсон. Ямааны бие дэх протейны хэмжээг тохируулснаар махны болон ноолуурын чиглэлээр өсгөх боломж бүрдсэн. Мелатонин (melatonin)-ыг ашиглан ямааны бие дэх тэжээллэг бодисуудын хэмжээг тохируулж, ноолуурын гарцыг 120 орчим граммаар нэмэгдүүлж чадсан байна. (Чанар нь бага зэрэг буурсан).

Хятадын ноолуурын үйлдвэрлэл Оёмол, нэхмэл бүтээгдэхүүний квотыг цуцалсны дараа

2005 оны эхний улиралд АНУ-ын ноолууран цамцны импорт өмнөх оны мөн үетэй харьцуулхад 69 хувиар өссөн байна. Хятад улсаас авсан ноолууран цамцны импорт 258 хувиар, Хонгконгоос авсан импорт 112 хувиар тус тус өсч, Тайландаас авсан импорт 84 хувиар буурсан байна. Оёмол, нэхмэл бүтээгдэхүүний квот хүчингүй болохоос өмнө Хятадын ноолууран цамцны үнэ 551 ам.доллар (12 ширхэг байсан бол квотгүй болсны дараа 384 ам.доллар) 12 ширхэг болж 30 хувиар буурсан байна<sup>4</sup>.

АНУ импортоос хамааралтай зарим төрлийн оёмол, нэхмэл бүтээгдэхүүнийг 2002 онд квотоос чөлөөлсөн. Үүний дараа АНУ дотоодын үйлдвэрлэлээ хамгаалах зорилгоор 2003 оны 12 дугаар сараас 2004 оны 12 дугаар сар хүртэл хугацаанд Хятадын сүлжмэл даавуу, цээживч, хослол өмд, цамц зэрэг бүтээгдэхүүний импортод хязгаарлалт тавьсан. Мөн 2004 оны 10 дугаар сараас 2005 оны 10 дугаар сар хүртэл хугацаанд Хятадын оймсон бүтээгдэхүүний импортод хязгаарлалт тавьсан байна.

АНУ-ын Оёмол, нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид хятадын хямд бүтээгдэхүүний импорт дотоодын зах зээлд “аюул” учруулж байна гэсэн үндэслэлээр Засгийн газартаа хандан 2004 оны 10-12 дугаар сарын хугацаанд

нийт 12 удаа өргөдөл гаргасан боловч 2004 оны 12 дугаар сард АНУ-ын шүүх цаашид энэ төрлийн өргөдлийг хүлээн авахгүй гэж мэдэгдсэн.

2005 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр АНУ-ын Засгийн газар өөрөө санаачлан даавуун сүлжмэл цамц, даавуун өмд, даавуун дотуур хувцаст хязгаарлалт тогтоох талаар хэлэлцүүлж эхэлсэн. Үүний дараа 2005 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр АНУ-ын үндэсний үйлдвэрлэгчид файбр материалтай өмд, цамц, даавуу болон файбр материалын хольцтой цамц, синтетик нарийн даавуу, файбр материалтай болон даавуун зузаан цамц, хослол өмд цамц, цээживч зэрэг 7 зүйлийн бүтээгдэхүүнд хязгаарлалт тавих өргөдөл гаргасан байна. **АНУ-ын Сенатаас Хятад улс юаний ханшаа уян хатан болгож чөлөөлөх хүртэл хятадын бүх төрлийн импортын бараанд 27.5 хувийн татвар тогтоохоор бэлтгэж байна**<sup>5</sup>.

Өнгөрсөн оны 12 дугаар сард Хятадын Төрийн Зөвлөлөөс квот хүчингүй болж буйтай уялдуулан хятадын оёмол, нэхмэл бүтээгдэхүүний экспортын хэт өсөлтийг хязгаарлах зорилгоор экспортын оёмол, нэхмэл бүтээгдэхүүний ширхэг бүрт 0.2 – 0.3 юань, нэг кг тутамд 0.5 юаний экспортын татвар тогтоосон боловч уг татвар экспортын өсөлтийг хязгаарлах нөлөө үзүүлж чадсангүй. АНУ-ын Худалдааны яамнаас гаргасан мэдээллээс үзэхэд 2005 оны эхний улиралд хятадын даавуун сүлжмэл цамц болон зузаан цамцны экспорт 1250 хувиар, даавуун өмд 1500 хувиар өссөн байна.

Хятад улс Дэлхийн худалдааны байгууллагад элсэн орсноор худалдаагаа хяналтгүй, хязгаарлалтгүй явуулж болно гэсэн ойлголттой байгааг Европын холбооноос ихээхэн шүүмжлэх боллоо. “Хятад улс өөрийн зах зээл дээр олон улсын шударга өрсөлдөөн явагдах үндсийг бүрдүүлж, ил тод болгох хэрэгтэй бөгөөд худалдаагаа чөлөөтэй бас шударга явуулах ёстой. Хэрэв шударга худалдааны стандартыг баримтлахгүй зөвхөн худалдааны ашигт чиглэн ажиллавал Европын холбоо төдийгүй ДХБ-ын гишүүн бусад орны

<sup>4</sup> “Cashmere Outlook – Trends, Price, Science of Fiber Identification” Cashmere and Camel Hair Manufacturer’s Institute of USA, April 12, 2005

<sup>5</sup> “G-7’s ‘Quiet Diplomacy’ Under Attack as China Keeps Dollar Peg” Bloomberg, April 13, 2005

зүгээс хязгаарлалт тавих болно” гэж ДХБ-ын Худалдааны Комиссар Питер Манделсон мэдэгджээ<sup>6</sup>. Европын холбоо Хятадын оёмол, нэхмэл бүтээгдэхүүний импортод хязгаарлалт тавих эсэх шийдвэрээ 4 дүгээр сарын 25-ны өдөр гаргах юм.

Хятадын Төрийн Зөвлөл ирэх 5 дугаар сараас эхлэн оёмол, нэхмэл бүтээгдэхүүний ширхэг бүрт 2-4 юаний экспортын татвар тогтоохоор төлөвлөж байгаа бөгөөд хэрэв татвар ийнхүү нэмэгдвэл урьдчилан хийсэн Гэрээний үнийн зөрүүг хэн хариуцах талаар Сянган болон Эх газрын оёмол, нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэгч томоохон компаниуд Төрийн Зөвлөлдөө асуудал тавихаар зэхэж байна.<sup>7</sup>

Манай улсын ноолуурын зах зээл өмнөд хөршийн зах зээлтэй хэрхэн уялдах вэ?

Манай өмнөд хөрш Хятад улс дэлхийн ноолуурын түүхий эдийн нөөцийн ихэнхийг үйлдвэрлэж байгаа бөгөөд цаашид дэлхийд нэртэй шилдэг загвар болон ноолуур дахин боловсруулах шилдэг технологийг нэвтрүүлэн дэлхийн ноолуурын бүтээгдэхүүний нийлүүлэлтэд үнэмлэхүй байр сууриа бататган хөгжих чиг хандлагатай байна.

Үүний зэрэгцээ Хятад улсад ноолуур боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагааны зардал болон ажиллах хүчний зардал бусад ноолуур үйлдвэрлэгч орнуудтай харьцуулахад хямд зэрэг давуу талууд бий.

Манай үндэсний орлогын 25 орчим хувийг бүрдүүлэгч, дотоодоос түүхий эдээ хангах боломжтой, мал аж ахуйд суурилсан үндэсний уламжлалт үйлдвэрлэлийн нэг болох ноолуурын үйлдвэрлэлийг цаашид өргөжин тэлж буй хятадын ноолуурын зах зээлтэй хэрхэн уялдуулж хөгжүүлэх нь анхаарал татах асуудал юм.

Ноолууран эдлэл нь оёдол, нэхмэл бүтээгдэхүүний ангилалд багтдаг бөгөөд сүүлийн үед АНУ, Европын холбооноос Хятадын оёдол, нэхмэл бүтээгдэхүүний импорт богино хугацаанд асар ихээр нэмэгдэж тэдгээр улсуудын дотоод эдийн засаг, зах зээл болон үйлдвэрлэгч нарт сөргөөр нөлөөлөх болсны

улмаас хятадын оёдол, нэхмэл бүтээгдэхүүний импортод хязгаарлалт тавихаар төлөвлөж байна. Манай үйлдвэрлэгчид энэ үйл явцыг анхааралтай ажиглан үйлдвэрлэлийн төлөвлөлтөө зохицуулж байх нь зүйтэй юм.

Хятадаас Европын холбоонд экспортлох зарим оёмол, нэхмэл бүтээгдэхүүний квотыг 1995 онд цуцалсаны дараа хятадын оёдол, нэхмэлийн салбарын үйлдвэрлэгч нарын дунд гарсан “үнийн дайн” болон зах зээлийн сегментийн төлөөх өрсөлдөөн нь 2005 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн дэлхий нийтээр оёмол, нэхмэл бүтээгдэхүүний квотыг цуцалсны дараа хятадын оёдол, нэхмэлийн салбарын үйлдвэрлэгч нарын дунд давтагдан гарч, хямд үнэтэй бүтээгдэхүүнийг хэт их хэмжээгээр гадаад орнуудад экспортлож байна.

Үүнийг Хятадаас АНУ болон Европын холбоонд 2005 оны 1 дүгээр сард гаргасан оёмол, нэхмэл бүтээгдэхүүний экспорт өмнөх оны мөн үетэй харьцуулахад тус тус 50-60 хувиар өссөн байгаагаас харж болно. Энэ өсөлт өнгөрсөн саруудад 70-80 хувь болж өссөн тооцоо гарчээ.<sup>8</sup> Энэ үйл явц хятадын ноолуурын зах зээлд мөн богино хугацаанд нөлөөлөх болов уу гэсэн таамаглалыг хятадын ноолуурын салбарын шинжээчид хийж байна. Энэхүү нөлөөлөл нь манай улсын ноолуурын экспортод ч мөн нөлөөлж болох талтай.

Хятад улсын Төрийн Зөвлөлөөс 2004 оны эхнээс эхлэн хагас боловсруулсан ноолуурын экспортыг багасгах бодлого баримтласны дүнд АНУ, Япон болон Европын зарим ноолуур үйлдвэрлэгч компаниуд өндөр технологийн дамжлага бүхий үйлдвэрлэлээ Хятад улс руу шилжүүлэн байршуулж байгаагаас үзэхэд манай улс мөн хагас боловсруулсан ноолуурын экспортын хэмжээг шууд бус бодлогын арга хэрэгслээр дамжуулан багасгах замаар гадаадын ноолуур үйлдвэрлэгчдийн өндөр технологи, хөрөнгө оруулалтыг татах боломж байж болох юм.

Монгол улсын жилд бэлтгэдэг ноолуурын 50 орчим хувийг хууль бусаар хил давуулан Хятад улсад экспортлодог байна<sup>9</sup>. Хэрэв

<sup>6</sup> “EU trade chief talks of curbs on China’s Exports” Free Republic <http://209.157.64.200/focus/f-news/1349846/posts>

<sup>7</sup> “Beijing may raise textile tariffs to curb exports” Financial Times by Alexandra Harney in Hong Kong, Geoff Dyer in Shanghai, and Alan Beattie in London Published: April 15 2005 03:00

<sup>8</sup> “China Dons Even Bigger Export Hat” by Evelyne Iritani, Don Lee and Maria Dickerson. “Times” magazine staff writers. March 11, 2005

ноолуурыг дахин боловсруулах шилдэг технологи манай улсад орж ирвэл манай улсын ноолуурын салбараас олох орлого 2 дахин нэмэгдэх боломжтой.

Дэлхийн ноолуурын түүхий эдийн 70 гаруй хувийг хянадаг Хятад улсын явуулж буй гадны технологи татах бодлогыг дэлхийн ноолуурын түүхий эдийн 18 орчим хувийг үйлдвэрлэдэг манай улс тусган үргэлжлүүлбэл илүү үр дүнтэй хэрэгжиж болох талтай юм.

Хятадын Төрийн Зөвлөл ийнхүү хагас боловсруулсан ноолуурын экспортыг Засгийн газрын бодлогын хүрээнд аажим багасган бүрэн боловсруулсан ноолууран бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх замаар үндэсний орлогоо нэмэгдүүлж байна. Манай улс энэ чиглэлээр ажиллах шаардлагатай. Манай улсад анх 1997 онд ноолуурын экспортын татвар тогтоох үед 1 кг ноолуурын үнэ 12000 төгрөг байсантай уялдуулан кг тутамд 4000 төгрөгөөр тогтоосон. Тухайн үед хувиар тогтоох санал гарч байсан боловч ноолуурын үнэ богино хугацаанд маш мэдрэмжтэй өөрчлөгддөг тул гаалийн татвар тооцох үнэ тодорхойлох тал дээр хүндрэл учирна гэсэн үндэслэлээр тогтмол хэмжээгээр тогтоож байсан. Одоо нэг кг ноолуурын үнэ дотоодын зах зээл дээр 32000 төгрөг<sup>10</sup> болоод байхад татварын хэмжээ хөдөлгөөнгүй байгааг анхаарах хэрэгтэй юм.

Иймээс өмнөд хөршийн авч хэрэгжүүлж буй ноолуурын бодлогыг ажиглан богино хугацаанд хариу арга хэмжээ авах замаар ажиллах шаардлагатай болж байна.

Хятадын үйлдвэрлэгчдийн хийж буй мэдээллээс ажиглахад ноолуурын наймаачид нь зах зээл дээрх ноолуурын үнийг аль болох ихээр савлуулахыг хичээдэг байхад ноолуурын үйлдвэрлэгчид үнийн тогтвортой байдлыг эрхэмлэдэг байна. Наймаачид ийнхүү

үнийг дээш доош нь огцом савлуулах замаар ашиг олдог боловч үүний дүнд ноолуурын үйлдвэрлэгч нар үргэлж хохирол амсч улмаар ноолууран бүтээгдэхүүний чанар мууддаг байна. Үүний эсрэг Хятадын ноолуурын үйлдвэрүүд нэгдсэн байдлаар тохиролцоо үүсгэн түр зуурын үнийн өөрчлөлтийг үл харгалзсан үнийн түвшинг баримтлаж ажилласнаар сүүлийн жилүүдэд ноолуурын үнийн хэлбэлзэл багассан байна. Үүнийг манай үндэсний үйлдвэрлэгч нар анхаарахад илүүдэхгүй бололтой.

Манай улсад ямааны тоо сүүлийн үед хэт хурдацтай нэмэгдэж бэлчээр муутгаж буй асуудлыг Хятадын төрийн байгууллагууд болон мал аж ахуйн эрдэм шинжилгээний байгууллагууд 1) улсын хэмжээний ноолуур үйлдвэрлэлийн хэмжээг бууруулахгүй байх мөн цаашид нэмэгдүүлэхгүй байх шаардлагыг харгалзан орчин үеийн үржил, селекцийн аргаар нэг ямаанаас гарах ноолуурын гарцыг нэмэгдүүлэх замаар ямааны тоог багасгах 2) ноолуурын гарц муутай үүлдрийн ямааны үүлдрийг устган, ноолуурын гарц сайтай ямааг үржүүлэх 3) ямааг бэлчээрлүүлэхийг багасгаж, фермерийн аргаар тэжээх зэрэг аргаар шийдвэрлэж байгааг бид анхааран судлах ёстой. Эрс тэс, хүйтэн уур амьсгалтай нөхцөлд ямааны ноолуурын чанар сайн байдаг тул ямааны фермерийн аж ахуйн ирээдүйн төлвийг цаашид ажиглан судлах шаардлагатай гэж үзэж байна.

Английн эрдэмтдийн хийсэн судалгаагаар өндөр бүсийн хуурай, эрс тэс, уур амьсгалтай газрын ямаа хамгийн сайн чанарын ноолууртай байдаг ажээ<sup>11</sup>

Иймээс Монголын ноолууран бүтээгдэхүүний гадаадад сурталчилгааг энэхүү чанар дээр үндэслэн сурталчилбал илүү үр дүнтэй байж болох юм.

<sup>9</sup> “Trade Policy Review of Mongolia” WTO Secretariat, WT/TPR/S/14515 February 2005

<sup>10</sup> “Монголын ноолуурын зах зээл дэх Хятадуудын тоглоомыг хэзээ болиулах вэ?” И.ОТГОНЖАРГАЛ (өнөөдөр 2005-04-08 083)

<sup>11</sup> “Scotland and China and Cashmere Trade” (CASHMERE) <http://www.american.edu/TED/cashmere.htm>